

БАТЛАВ.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА/Б.ГАНЗОРИГ/

**ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН
УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2019 оны 03 дүгээр сарын 04. Дугаар ТТХ.ХБ - 01/2019 Сайншанд хот

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Газрын тухай хууль, 2002 он; - Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам"; - Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 сарын 03-ны өдрийн 09/08 дугаар тогтоолоор баталсан 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Газрын тухай хуульд заасны дагуу Дорноговь аймгийн 14 сумын төв болон бусад хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа /цаашид "хянан баталгаа" гэх/-ны ажлыг гүйцэтгэж, мониторингийн цэг байгуулах, урьд нь хийсэн хянан баталгааны ажлын үр дүнтэй харьцуулж, хянан баталгааны мэдээллийн санг загварын дагуу үүсгэж, хянан баталгааны нэгж талбар бүрээр хянан баталгааны дүгнэлт, зураглал боловсруулах
3.	Хамрах хүрээ	<ul style="list-style-type: none">• Нийт 14 сумын хот тосгон бусад суурин газар (122907.8 га)<ol style="list-style-type: none">1. 1-р багц Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Сайншанд, Өргөн 68009,8 га2. 2-р багц Даланжаргалан, Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ, Замын-Үүд 54898 га• Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр олгохоор төлөвлөсөн газар
4.	Ажлын иж бүрдэл	<ol style="list-style-type: none">1. Сум тус бүрээр хянан баталгааны ажлын тайлан (цаасан, тоон хэлбэрээр)2. Сум тус бүрээр хянан баталгааны зураг (цаасан, тоон хэлбэрээр) <p>А. Тоон зургийг дараах хэлбэрээр өгнө.</p> <ol style="list-style-type: none">1. Нэгж талбарын сүлжээний зураг, ".jpg", 1:100000 масштабаар (файлын нэр: <i>Argalant.jpg</i>)

		<p>2. Хуваалга хийсэн схем зураг, "jpg", А3 цаасны хэмжээгээр (файлын нэр: <i>Argalant_scheme</i>)</p> <p>3. Хувааж хэвлэсэн зураг, "jpg", А3 цаасны хэмжээгээр (файлын нэр: <i>Argalant_jpg1</i>)</p> <p>Б.Тайланг тоон хэлбэрээр дараах байдлаар өгнө.</p> <p>4. Үндсэн тайлан, Arial фонт, "doc", "pdf" (файлын нэр: <i>Argalant_tailan</i>)</p> <p>5. Нэгдсэн хүснэгт, "exc" (файлын нэр: <i>Argalant_husnegt1</i>)</p> <p>6. Нөлөөллийн товчоо, "exc" (файлын нэр: <i>Argalant_husnegt2</i>)</p> <p>7. Дүгнэлт, паспорт (файлын нэр: T2116000467)</p> <p>В.Хавсралт материалыг тоон хэлбэрээр дараах байдлаар өгнө.</p> <p>8. Дараах мэдээллийг нэгж талбарын дугаараар 1 фолдерт хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хээрийн судалгааны фото зураг, "jpg", (файлын нэр: <i>Heer_photo</i>) • Скайнердсан ургамлын бичиглэл, "pdf" (файлын нэр: <i>urgam_bichiglel</i>) • Скайнердсан хөрсний бичиглэл, "pdf" (файлын нэр: <i>hurs_bichiglel</i>) • Скайнердсан лабораторын шинжилгээний дүн, "pdf", (файлын нэр: T2116000467) <p>9. Боловсруулалт хийсэн агаар, сансрын зураг (фолдерийн нэр: <i>Argalant_хиймэл дагуулын нэр</i>)</p> <p>10. Arc GIS ажлын файл (фолдерийн нэр: <i>Argalant_mxd</i>)</p> <p>11. "gdb" өргөтгөлтэй дата бааз (фолдерийн нэр: <i>Argalant_gdb</i>)</p> <p>12. Топологи файл (фолдерийн нэр: <i>Argalant_top</i>)</p> <p><i>Жич: Оноосон нэрийг жишээ байдлаар оруулав.</i></p>
5.	Гүйцэтгэх ажлын үе шат, хэмжээ	<p>1. Бэлтгэл ажлын үе шат</p> <ul style="list-style-type: none"> - Хянан баталгаа хийх газрын байгаль, газарзүйн нөхцлийн судалгааны мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх, зураглах; - Хөрс, ургамлан нөмрөг, гадаргын болон гүний усны судалгааны материал цуглуулах, дүн шинжилгээ хийх; - Газрын кадастрын зураг, мэдээллийн сан ашиглан газрын ашиглалтын зориулалтын талаар судалж, зураглах; - Өмнө хийгдсэн хянан баталгааны тайлан, паспорт болон материалыг цуглуулж судлах, харьцуулан дүгнэлт хийх зорилгоор тоон хэлбэрт оруулах, мэдээллийг нэгтгэн дүгнэх;

		<ul style="list-style-type: none">- Тоон байр зүйн зургийг бэлтгэж, газрын кадастрын зурагтай давхцуулж, ажлын зураг зохиох, хянан баталгааны нэгж талбар, дэд нэгж талбарыг нарийвчлан тодорхойлж, зураглах;- Агаар, сансрын зургаас тодорхойлох боломжтой газрын гадаргын өөрчлөлт, хөрс-ургамлан нөмрөгийн төлөв байдлыг тодруулан, өөрчлөлтийн хил заагийг ажлын зурагт тусгах;- Өмнөх хянан баталгааны ажлын хүрээнд тодорхойлсон дээж авсан цэгүүдийн байршлыг ажлын зурагт оруулах;- Бусад байгууллагаас аймгийн хэмжээнд хөрсний бохирдолыг тодорхойлж байгаа цэгийн байршил, шинжилгээний мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх <p>2. Хээрийн судалгаа</p> <ul style="list-style-type: none">- Дэд нэгж талбар бүрээр хөрс, ургамлын бичиглэл, дээж авах- Хөрсний зулгаралт, элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг тодорхойлон ажлын зурагтай тулган нарийвчлах, ялгарал бүрээс дээж авах;- Байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас элэгдэж эвдэрсэн газрын хэмжээ байршлыг тогтоох- Хөрсний физикийн болон хими, биологийн бохирдолд орсон газруудын байршил, хэмжээг тодорхойлох- Хүнд металлын бохирдолд орсон газруудын байршил, хэмжээг тодорхойлох- Хөрсний эрүүл ахуйн байдлыг тодорхойлох дээж авах- Байнгын ажиллагаатай мониторингийн цэгүүдийг тогтоох, тэдгээрийг устахааргүй, нөлөөлөлд орохооргүй газарт байршуулах- Газрын гадаргын төлөв байдал, гадаргын механик бохирдлын хил заагийг тогтоон зурагт оруулах;- Газар ашиглалтын аюулгүй байдал, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үзүүлэлтийг судлан тогтоох;- Бохирдолын шалтгаан, нөхцлийг судлан тухай бүрт нь зөвлөмж боловсруулах <p>3. Материал боловсруулалт</p> <ul style="list-style-type: none">- Хөрсний дээжинд хими-физикийн, хүнд металлын, эрүүл ахуйн шинжилгээ хийх, дүн шинжилгээ хийх, нэгтгэх- Судалгаагаар тодорхойлогдсон газрын төлөв байдал, чанар, нөлөөллийн бүх үзүүлэлтийг кодлон, ажлын зурагтай холбон, мэдээллийн сан үүсгэж, хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг, хянан баталгааны дэлгэрэнгүй ба товчоо хүснэгтийг боловсруулах;
--	--	--

		<ul style="list-style-type: none"> - Хянан баталгааны нэгж талбар бүрийн дүгнэлтийг эцэслэн боловсруулах; - Эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газрыг ашиглалтын зориулалтаар нь ангилан газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу экспликаци гаргах; - Хянан баталгааны үзүүлэлт бүрийг өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах, өөрчлөлтийг тогтоох; - Сум тус бүрээр хянан баталгааны сүлжээний зураг хийх; - Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан бичих, дүгнэлт гаргах;
6.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> - "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам" Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол; - "Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай" Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын баталсан "Хот тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын удирдамж", "Хот тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын мэдээллийн сангийн загвар" - Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 3298-90; - Байгаль хамгаалал, Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3297-91; - Хүнд металлын агууламж тодорхойлох, MNS2306:1986, MNS ISO 11466:2007 стандарт; - Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008; - Хөрсний биологийн бохирдлын үзүүлэлтүүд, гэдэсний бүлгийн бичил биетнүүд, агааргүйтэн бичил биетнийг тодорхойлох MNS 4697-98, MNS4694-1998 стандарт; - Газар зүйн мэдээллийн системийн Arc GIS 10.5 програм хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах, - Сүүлийн 5 жилийн хугацаанд авсан өндөр нарийвчлалын сансрын зураг ашиглах <p>Хөрсний шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторит дараах шинжилгээг хийлгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээ - Хүнд металын шинжилгээ - Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ (Гэдэсний савханцар, Перпенгисийн таньц).

7.	Ажил гүйцэтгэх хугацаа	Эхлэх: 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Дуусах: 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр
8.	Ажлын хяналт, шалгалт	Хяналтын зардлыг нийт үнийн дүнгийн 5 хувиар тооцно. Хяналтыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хийж гүйцэтгэнэ. Захиалагч ажлын 3 үе шатанд хяналт тавих бөгөөд хээрийн ажлын хяналтыг хээрийн ажил гүйцэтгэх явцад хийнэ. Гүйцэтгэгч тогтоосон хугацаанд 3 үе шатны тайланг ирүүлэх шаардлагатай. Захиалагч ажил шалгасан акт гаргаж, хяналтын ажлыг баталгаажуулна.
9.	Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> - Бэлтгэл ажлын тайлан, цаас болон тоон хэлбэрээр 1 хувь - Хээрийн ажлын тайлан, цаас болон тоон хэлбэрээр 1 хувь - Эцсийн тайлан, цаас болон тоон хэлбэрээр - 3 хувь /тус бүр/ - Сансрын болон хянан баталгааны сүлжээний зургийг тоон хэлбэрээр – 3 хувь - Сум тус бүрийн хянан баталгааны сүлжээний зургийг хэвлэмэл хэлбэрээр – 3 хувь
10.	Захиалагч байгууллага	Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар
11.	Гүйцэтгэгч байгууллага	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээд
12.	Санхүүжилт, эх үүсвэр	Орон нутгийн төсөв, 60 000 000 /Жаран сая төгрөг/
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг гэрээний нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

ИНЖЕНЕР, ХАЙГУУЛ
МОНИТОРИНГИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

О.ОЮУНЦЭЦЭГ